



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 4/19

Арвайхээр сум

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ёс зүйн дэд хорооны дарга: Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга С.Дашхорол

Гишүүд: Захиргаа хуулийн тасгийн дарга А.Ганчимэг

Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч Ц.Даваасүрэн

Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч Р.Наранчулуун

Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч Ж.Амарбаясгалан

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шалгах, дүгнэлт гаргах, дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах, байгууллагад ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тайлан мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэхийг ёс зүйн дэд хорооны даргад даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн тасгийн дарга (А.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  НЭРДЭНЭСУВД



621001037